



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 372

Улаанбаатар хот

“Монгол даатгал” ХХК-ийг “Хорго хайрхан” ХК-д
нэгтгэхийг зөвшөөрч, үнэт цаасны бүртгэлийн
болон оноосон нэрийн өөрчлөлтийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 75 дугаар зүйлийн 75.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.1.2, 5.2.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 12 дугаар хавсралт “Даатгагчаас үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг бусдад шилжүүлэх болон нэгтгэх үед гаргах өргөдлийг хянан шийдвэрлэх журам”-ын 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол даатгал” ХХК-ийг “Хорго хайрхан” ХК-д нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Нэгтгэх замаар өөрчлөн байгуулсантай холбоотой “Монгол даатгал” ХХК-ийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг “Хорго хайрхан” ХК-д шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

3. Даатгалын үйл ажиллагаанаас өөр үйл ажиллагаа эрхлэхийг “Хорго хайрхан” ХК-д хориглосугай.

4. “Хорго хайрхан” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 135,126 /нэг зуун гучин таван мянга нэг зуун хорин зургаа/ ширхэг хувьцааг тус компанид нэгдэж буй “Монгол даатгал” ХХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 63,997,215 /жаран гурван сая есөн зуун ерэн долоон мянга хоёр зуун арван тав/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн нийт нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 64,132,341 /жаран дөрвөн сая нэг зуун гучин хоёр мянга гурван зуун дөчин нэг/ ширхэг хувьцаа болгон нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-г үүрэг болгож, энэхүү тогтоолын хавсралтад заасны дагуу үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа/-д зөвшөөрсүгэй.

5. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Хорго хайрхан” ХК /Ч.Энх-Амгалан/-д үүрэг болгосугай:

1/ “Хорго хайрхан” ХК-ийн хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлэх;

2/ Компанийг өөрчлөн байгуулж, нэгдэж байгаа компанийн өмчлөлийн хөрөнгийг “Хорго хайрхан” ХК-д шилжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, шинэчилсэн дүрмийг хуульд

F:\ajil 2019\Blank\Togtool.doc

000768

заасан журмын дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох баримт бичгийн хамт ирүүлэх;

3/ 2019 оны жилийн эцсийн тайланд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд орсон өөрчлөлтийг тусгах;

4/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам"-д заасан мэдээллийг тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;


5/ Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор баталсан "Компанийн засаглалын кодекс"-ыг үйл ажиллагаандаа чанд баримталж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж ажиллах.

6. "Монгол даатгал" ХХК-ийн эрх, үүрэг хариуцлагыг "Хорго хайрхан" ХК-д шилжүүлсэнтэй холбоотой "Хорго хайрхан" ХК-ийн оноосон нэрийг "Монгол даатгал" ХК болгон өөрчилснийг бүртгэсүгэй.

7. Нэгтгэх замаар бүртгэлд орсон өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг "Хорго хайрхан" ХК /Ч.Энх-Амгалан/-д үүрэг болгосугай.

8. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 11 дугаар сарын 16-ны өдрийн
372 дугаар тогтоолын хавсралт

“Хорго хайрхан” ХК-ийн хувьцааны тоо

№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Хувьцааны тоо ширхэг	Эзлэх хувь
1.	“Милениум Секюритис Менежмент Лимитед” ХХК /шинээр гаргасан хувьцаа/	63,997,215	99,79%
2	“Хорго хайрхан” ХК	109,921	0,17%
3	Бусад 241 хувьцаа эзэмшигч	25,205	0,04%
	Нийт дүн	64,132,341	100%